



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

21

2014 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн ажилтны гадаад сургалтыг салбарын хүний нөөцийн бодлого, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээтэй уялдуулах, гадаад сургалтын үр дүн, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтанд хамруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг эрүүл мэндийн ажилтнуудад сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ), нийт эрүүл мэндийн байгууллагын дарга/захирал нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, жил бүрийн тайланг “Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл”-өөр хэлэлцэж, ил тод тайлагнаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга (А.Эрдэнэтуяа), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ


081579

22  
Эрүүл мэндийн сайдын  
2014 оны 04 сарын 11 өдрийн  
119 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАНГ ГАДААД ОРОНД  
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ ЖУРАМ

**Нэг. Ерөнхий зүйл.**

- 1.1. Улсын төсөв, “Эрүүл мэндийг дэмжих сан”-ийн санхүүжилт, Засгийн газар хоорондын болон Эрүүл мэндийн яам (ЭМЯ), олон улсын (ОУ)-ын байгууллагуудын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээр, хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг 1 сараас 1 жил хүртэлх хугацаагаар гадаад оронд мэргэжлийн сургалтанд хамруулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Энэ журмаар зохицуулах эрүүл мэндийн ажилтны гадаад сургалт гэдэгт мэргэжил дээшлүүлэх сургалт, үндсэн мэргэшлийн сургалтын тодорхой хугацааны сургалт хамаарна.
- 1.3. Мэргэжил дээшлүүлэх сургалт, үндсэн мэргэшлийн сургалт гэдгийг Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтран баталсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-д тодорхойлсноор ойлгоно.
- 1.4. Төрийн сангийн тэтгэлгээр бакалаврын болон магистр, доктор, докторын дараах сургалтанд суралцагсадтай холбоотой асуудал нь энэхүү журамд хамаарахгүй бөгөөд Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулагдана.
- 1.5. Улсын Их Хурал, Засгийн газар, Эрүүл мэндийн сайдын санаачлага, шийдвэрээр, мөн салбарын бодлоготой нийцүүлэн онцгойлон үзсэн болон хойшлуулалшгүй зохион байгуулах шаардлагатай гадаад сургалтад эрүүл мэндийн ажилтныг хамруулахад сонгон шалгаруулалт явуулахгүй.
- 1.6. Суралцагчийн харьяалах байгууллага нь энэхүү журамд заасан нийтлэг эрх, үүргээс гадна бусад нэмэлт асуудлыг тусгасан “Гадаад оронд мэргэжлийн сургалтанд суралцах эмнэлгийн мэргэжилтэнтэй хийх гэрээ” (цаашид гэрээ гэх)-г суралцагч болон Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-тэй байгуулж, ЭМХТ-ийн захирлаар баталгаажуулна.
- 1.7. Энэхүү журам болон журмын 1.6-д заасан гэрээнд өөрөөр заасан бол Засгийн газар хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээр, ЭМЯ болон ОУ-ын байгууллагын хооронд байгуулсан гэрээ, сургалтыг санхүүжүүлж буй ОУ-ын байгууллагаас тавьсан шаардлага, эрх, үүргийг дагаж мөрдөнө.
- 1.8. Суралцагч нь харьяалах байгууллагадаа ажиллахаа больж, бусад төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад шилжсэн тохиолдолд энэ журмын 5 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн байгууллагын нийтлэг эрх, үүрэг нь шинээр ажиллуулах эрүүл мэндийн байгууллагад шилжих бөгөөд 6 дугаар зүйлд заасан суралцагчийн нийтлэг эрх, үүрэг хэвээр хадгалагдана.



**Хоёр. Гадаад сургалтын зохион байгуулалт.**

2.1. ЭМЯ-ны эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хөгжлийн асуудал хариуцсан нэгж нь жил бүрийн I улиралд багтаан гадаад оронд эрүүл мэндийн ажилтныг сургах чиглэлийг салбарын хүний нөөцийн бодлого, хэрэгцээтэй уялдуулан тогтоож, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

2.2. ЭМХТ нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан чиглэлийг үндэслэн сургалтыг зохион байгуулна.

2.3. ЭМЯ нь эмнэлгийн мэргэжилтнийг сургах чиглэлээр гадаадын эрүүл мэндийн байгууллагатай харилцаа холбоо тогтооход дэмжлэг үзүүлж ажиллана.

2.4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тухайн жилд гадаад оронд эрүүл мэндийн ажилтныг сургах чиглэл, суралцагчид тавигдах шаардлагын талаарх мэдээллийг ЭМХТ нь холбогдох төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлнэ.

2.5. Эрүүл мэндийн байгууллага нь батлагдсан чиглэлийн хүрээнд, суралцагчид тавигдах шаардлагыг хангасан эрүүл мэндийн ажилтнаа гадаад оронд мэргэжлийн сургалтанд хамруулах албан хүсэлтийг ажилтны холбогдох материалын хамт ЭМХТ-өөс тогтоосон хугацаанд тус байгууллагад ирүүлнэ. Үндсэн мэргэшлийн сургалтанд суралцаж буй эмнэлгийн мэргэжилтний хувьд тухайн сургалтыг хариуцаж байгаа сургалт эрхлэгч байгууллага харьяалах эрүүл мэндийн байгууллага нь болно.

2.6. ЭМЯ-ны салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хөгжил хариуцсан нэгж болон ЭМХТ-ийн төгсөлтийн дараах сургалтын зохион байгуулалт хариуцсан нэгжийн төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсгийг ЭМХТ-ийн захирлын шийдвэрээр жил бүр шинэчлэн байгуулна.

2.7. Гадаад сургалтанд хамрагдах эрүүл мэндийн ажилтанг дараах хэлбэрээр шалгаруулна.

- 2.7.1. Суралцагчид тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг нотолсон баримт бичгүүдийг үнэлэх;
- 2.7.2. Гадаад хэлний мэдлэгийн түвшинг тогтоох.

2.8. Журмын 2.6-д заасан ажлын хэсэг нь эрүүл мэндийн байгууллагуудаас нэр дэвшүүлж ирүүлсэн эрүүл мэндийн ажилтны баримт бичгийг судлан, суралцагчид тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэх талаар эхний шалгаруулалт явуулах бөгөөд уг болзол шаардлагыг хангаагүй эрүүл мэндийн ажилтныг бүртгэлээс хасч, энэ тухай нэр дэвшүүлж ирүүлсэн эрүүл мэндийн байгууллагад нь мэдэгдэнэ.

2.9. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн тохиолдолд тухайн эрүүл мэндийн ажилтанг шалгаруулалтаас шууд хасна.

2.10. Хэрэв сургалтыг зохион байгуулах гадаадын байгууллага нь суралцагчид тодорхой шаардлагыг тавиагүй тохиолдолд хамтарсан ажлын хэсэг нь тухайн сургалтын хөтөлбөр, салбарын хүний нөөцийн холбогдох эрх зүйн баримт бичигтэй нийцүүлэн тавигдах шаардлагыг тогтоож болно. Энэ тохиолдолд журмын 3.6-д заасныг баримтална.

2.11. Ажлын хэсэг нь тогтоосон шаардлагын дагуу ирүүлсэн баримт бичгүүдийг нягтлан шаардлага тус бүрт нь үнэлгээ өгнө.

2.12. Өрсөлдөөнийг хангах зорилгоор тухайн чиглэлээр суралцуулах боломжтой эрүүл мэндийн ажилтны тоог харгалзан уг тооноос 2 дахин олон нэр дэвшигчдийг эхний шалгаруулалтаар онооны дарааллаар жагсаана. Хэрэв нэр дэвшүүлсэн эрүүл мэндийн ажилтны тоо нь суралцуулах тоонд хүрэхгүй эсвэл уг тооноос 2 дахин олон биш тохиолдолд онооны дарааллын дагуу бүх нэр дэвшигчдийг жагсааж дараагийн шалгаруулалтанд оролцуулна.

2.13. Дараагийн шалгаруулалтанд 2.12-т заасан эмнэлгийн мэргэжилтнүүдээс тухайн сургалт явагдах хэл дээр ярилцлага хийнэ. Шаардлагатай тохиолдолд бичгийн шалгалт авч болно.

2.14. Эрүүл мэндийн ажилтны гадаад хэлний мэдлэгийн түвшинг тогтоохдоо тухайн хэл дээр сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулж, 2.13-т заасны дагуу шалгаруулалтыг явуулна.

2.15. Гадаад сургалтанд хамрагдах эрүүл мэндийн ажилтаны тухайн сургалт явагдах хэлний мэдлэгийн түвшин дундаас дээш тохиолдолд шаардлага хангасан гэж үзнэ.

2.16. Гадаад хэлний мэдлэгийн түвшинг үнэлэх шалгалттай холбоотой гарах зардлыг тухайн гадаад сургалтын зардлаас тооцож гаргана.

2.17. Энэхүү журмын 2.7.1-д заасан суралцагчид тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг нотолсон баримт бичгүүдийн үнэлгээнд 50 хүртэл оноо, 2.7.2-т заасан шалгалтанд 50 хүртэлх оноог тус тус өгнө.

2.18. Журмын 2.7-д заасан багц шалгаруулалтын нийт оноо 80 ба түүнээс дээш тохиолдолд шалгаруулалтанд тэнцсэн гэж үзнэ.

2.19. Журмын 2.7-д заасан багц шалгаруулалт бүрээр байр эзлүүлсэн жагсаалтад хоёуланд нь эхний байрт шалгарсан эрүүл мэндийн ажилтныг нэгдүгээрт жагсаах бөгөөд хэрэв хоёр шалгаруулалтанд тэнцсэн эрүүл мэндийн ажилтны тоо нэгээс их байвал нийт онооны жагсаалтыг харгалзана.


2.20. Ажлын хэсэг шалгаруулалтын дүнг хуралдаанаараа хэлэлцэж, тэнцсэн эрүүл мэндийн ажилтны нэрсийг, үндэслэлийн хамт ЭМХТ-ийн захиралд хүргүүлнэ.

2.21. ЭМХТ-ийн захирал нь ажлын хэсгийн дүнг харгалзан тухайн жилд гадаад сургалтанд хамрагдах эрүүл мэндийн ажилтнуудын нэрсийг баталгаажуулж, сургалттай холбоотой үйл ажиллагааг энэхүү журмын дагуу зохион байгуулна.

2.22. Журмын 2.18-д заасны дагуу шалгаруулалтанд тэнцсэн боловч тухайн жилд гадаад оронд сургах тоонд багтаж чадаагүй 2 хүртэлх эрүүл мэндийн ажилтныг сургалтын чиглэл тус бүрт байр эзэлсэн жагсаалтын дагуу нөөцөд бүртгэж дараагийн ижил төрлийн сургалт зохион байгуулагдах үед харгалзан үзнэ.

**Гурав. Эрүүл мэндийн ажилтанг гадаад сургалтанд хамруулахад баримтлах зарчим.**

3.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан чиглэлийг баримтлах;



- 3.2. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн ажилтныг хамруулах;
- 3.3. Үр дүнтэй, санхүүжилтийн үр ашигтай сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах байгууллагыг сонгох;
- 3.4. Гадаад сургалтын талаарх мэдээллийг эрүүл мэндийн ажилтнуудад ил тод мэдээлэх;
- 3.5. Эрүүл мэндийн байгууллагаас нь дэмжсэн тохиолдолд нэр дэвшсэн эрүүл мэндийн ажилтанг сонгон шалгаруулалтанд оролцуулах;
- 3.6. Эрүүл мэндийн ажилтныг гадаад сургалтанд нэр дэвшүүлэхэд ажлын үр дүн, мэргэжлийн ёс зүй, ур чадвар, цаашид ажиллах идэвхи, санаачилга, гадаад хэлний мэдлэгийг нэн тэргүүнд харгалзах;
- 3.7. Зөвхөн суралцагчид тавигдах шаардлагыг хангасан эрүүл мэндийн ажилтанг сургалтанд хамруулах;
- 3.8. Нэр дэвшигчийг сургалтанд хамруулах эсэх талаарх шийдвэрийг сонгон шалгаруулалтын хамтарсан ажлын хэсгээр шийдвэрлэх;
- 3.9. Энэ журмын дагуу 1-6 хүртэлх сарын сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтанг 2 жил, 6-12 сарын сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтанг 3 жилийн хугацаанд тус тус улсын төсөв, "Эрүүл мэндийг дэмжих сан"-ийн санхүүжилт, Засгийн газар хоорондын болон ЭМЯ, ОУ-ын байгууллагуудын хооронд байгуулсан гэрээ, хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 1 сараас 1 жил хүртэлх хугацааны гадаад сургалтанд хамруулахгүй байх (ЭМЯ болон ОУ-ын байгууллагуудын хооронд байгуулсан зарим гэрээ, хэлэлцээр, хамтран хэрэгжүүлж буй төсөлд заасны дагуу, эсвэл ЭМЯ-аас бодлогоор хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд шинэ технологийг эзэмшүүлэхээр эмнэлгийн мэргэжилтэнг давтан сургах тохиолдолд энэ заалт хамаарахгүй).

#### **Дөрөв. ЭМХТ-ийн нийтлэг эрх, үүрэг.**

##### **4.1. ЭМХТ-ийн нийтлэг эрх:**

- 4.1.1. Сургалтын хөтөлбөрийн агуулгыг хянах, санал өгөх;
- 4.1.2. Сургалтын хугацаанд суралцагчийн сурлага, сахилга бат, холбогдох бусад мэдээллийг сургалт зохион байгуулж байгаа талаас тогтмол авах;
- 4.1.3. Сургалтын хугацаанд болон сургалтын дараа суралцагчаас сургалтын явц, ирээд хийсэн ажлын үр дүнгийн талаар бичгээр тайлан авах;
- 4.1.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг эрүүл мэндийн байгууллага, суралцагчаас шаардах;
- 4.1.5. Суралцагч гэрээг зөрчсөн эсвэл хангалтгүй биелүүлсэн тохиолдолд сургалтаас эгүүлэн татах эсвэл хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэх буюу энэ тухай саналаа ЭМЯ, суралцагчийн харьяалах байгууллагын эрх бүхий албан тушаалтанд уламжилж, шийдвэрлүүлэх.

4.1.6. Суралцагч гэрээг зөрчсөн эсвэл хангалтгүй биелүүлсэн тохиолдолд сургалттай холбоотой гарсан зардлыг нөхөн төлүүлэх.

4.2. ЭМХТ-ийн хүлээх нийтлэг үүрэг:

4.2.1. Сургалтыг зохион байгуулах гадаад орны эрүүл мэндийн байгууллагуудтай холбогдож, сургалтын бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай тохиолдолд гэрээ, хэлэлцээр байгуулах ажлыг эрх бүхий албан тушаалтанд уламжлан журмын дагуу шийдвэрлүүлэх;

4.2.2. Богино хугацаанд хамгийн бага зардлаар үр дүнтэй сургалт явуулах гадаадын эрүүл мэндийн байгууллагыг сонгох;

4.2.3. Сургалтын санхүүжилтийг хууль, журмын дагуу шуурхай шийдвэрлэх;

4.2.4. Суралцагчийн харьяалах байгууллагаас ирүүлсэн ЭМХТ болон суралцагчтай байгуулах гэрээг хянаж, баталгаажуулах;

4.2.5. Гадаад сургалттай холбоотой шаардлагатай мэдээллээр ЭМЯ, бусад холбогдох байгууллагуудыг үнэн зөв мэдээллээр шуурхай хангах;

4.2.6. Гадаад сургалтанд хамрагдах мэргэжилтнүүдэд удирдамж чиглэл өгөх, тэднээс гаргасан санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, шийдвэрлүүлэх;

4.2.7. Гадаад сургалтын талаарх дэлгэрэнгүй бичмэл тайлан болон санхүүжилтийн зарцуулалтын тайланг жил бүр ЭМЯ-ны холбогдох нэгж болон Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлд хүргүүлэх;

4.2.8. Гадаад сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны талаар мэдээний санг хөтлөх, тогтмол баяжилт хийх;

4.2.9. Гэрээг дүгнэх, үр дүнг тооцох.

**Тав. Эрүүл мэндийн байгууллагын нийтлэг эрх, үүрэг.**

5.1. Эрүүл мэндийн байгууллагын нийтлэг эрх:

5.1.1. Гадаад оронд эмнэлгийн мэргэжилтнийг сургалтанд хамруулахтай холбоотой мэдээллийг холбогдох байгууллагуудаас авах;

5.1.2. Журмын 3 дугаар зүйлд заасныг баримтлан гадаад оронд сургалтанд хамруулах эрүүл мэндийн ажилтныг нэр дэвшүүлэх;

5.1.3. Гадаад оронд мэргэжлийн сургалтанд эрүүл мэндийн ажилтныг хамруулахтай холбоотой сонгон шалгаруулалтын асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, хүсэлт гаргаж, шийдвэрлүүлэх.

5.2 Эрүүл мэндийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг:

5.2.1. ЭМЯ, ЭМХТ-өөс зарласан гадаад сургалтын талаарх мэдээллийг байгууллагын нийт эрүүл мэндийн ажилтнуудад ил тод мэдээлэх;

5.2.2. Гадаад оронд сургалтанд хамрагдах эрүүл мэндийн ажилтныг нэр дэвшүүлсэн тухай мэдээллийг байгууллагын нийт ажилтнуудад ил тод танилцуулах;

5.2.3. Өөрийн байгууллагаас нэр дэвшүүлж байгаа эрүүл мэндийн ажилтны мэдээлэл, холбогдох баримт бичгийн үнэн зөв эсэхийг нягталж, энэ талаар бүрэн хариуцах;

5.2.4. Энэхүү журмын 1.6-д заасан гэрээг байгуулах;

5.2.5. Сургалтын хөтөлбөрийг дэмжин, агуулга болон хөтөлбөрийг сургалт зохион байгуулж буй сургалтын байгууллагатай урьдчилан зөвшилцөх;

5.2.6. Суралцагчийг суралцах хугацаанд үндсэн байгууллага нь цалингийн 60 хувийг тооцож олгох (Үндсэн мэргэшлийн суралцагчдад тэтгэлэгийг бүрэн олгох);

5.2.7. Суралцагчийг гадаад оронд суралцах хугацаанд ажлын байрыг нь хадгалах, эгүүлэн ажлын байранд нь ажиллуулах;

5.2.8. Суралцагч нь гэрээний хугацаа дуусаагүй байхад ажлаас чөлөөлөгдөх тохиолдолд энэ тухай ЭМХТ, ЭМЯ-нд урьдчилан мэдээлэх;

5.2.9. Суралцагчийг олж авсан мэдлэг, ур чадвар, шинэ санаачилгаа хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

### **Зургаа. Суралцагчийн нийтлэг эрх, үүрэг.**

#### *6.1. Суралцагчийн нийтлэг эрх:*

6.1.1. Гадаад оронд эрүүл мэндийн ажилтныг сургалтанд хамруулахтай холбоотой мэдээллийг өөрийн байгууллага болон холбогдох бусад байгууллагуудаас шаардаж авах;

6.1.2. Шаардлагатай тохиолдолд байгууллага, бусад холбогдох эрх бүхий албан тушаалтнаас тодорхойлолт гаргуулан авах;

6.1.3. Сургалтын хугацаа, хөтөлбөр, агуулгын талаар харьяалах байгууллагын эрх бүхий албан тушаалтанд саналаа уламжлах;

6.1.4. Сургалтаа дуусгаж ирээд үндсэн ажлын байрандаа томилогдон ажиллах;

6.1.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг ЭМХТ, өөрийн харьяа байгууллагаас хүсэх.

#### *6.2 Суралцагчийн хүлээх нийтлэг үүрэг:*

6.2.1. Өөрийн талаарх мэдээлэл, холбогдох баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх;

6.2.2. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу амжилттай суралцах;

6.2.3. Суралцах хугацаандаа ЭМХТ болон харьяалах байгууллагатайгаа эргэх холбоотой байж, сургалтын явц, үр дүнгийн талаар бичгээр тайлагнах;

6.2.4. Суралцаж буй орны хууль, тогтоомж, ёс заншлыг хүндэтгэн, суралцагсдад тогтоосон дэг журмыг чанд сахих;

6.2.5. Сургалтын үеэр холбогдон гарах бусад (санхүүжилтэд багтаагүй) зардлыг өөрөө хариуцах (жишээ нь: эрүүл мэндийн болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан гарах зардлууд);

6.2.6. Сургалтаа дуусмагц эх орондоо эргэн ирэх;

6.2.7. Сургалтын талаар, цаашид хийх ажил болон хийсэн ажлын үр дүнгийн талаар байгууллагын удирдлага, нийт ажилтнуудад ил тод мэдээлж байх;

6.2.8. Сургалтаас олсон мэдлэг, ур чадвартаа тулгуурлан шинэ санал, санаачлагыг байгууллагын үйл ажиллагаанд заавал нэвтрүүлж, үр дүнг тооцож, гэрээ байгуулсан талуудад тайлагнах;

6.2.9. Сургалтанд хамрагдаж дууссаны дараа харьяалах байгууллагадаа эсвэл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бусад төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад шилжсэн тохиолдолд дор дурдсан хугацаагаар заавал ажиллах. Үүнд:

- 1- 3 хүртэлх сарын сургалтанд хамрагдсан тохиолдолд 3-аас доошгүй жил
- 3-6 хүртэлх сарын сургалтанд хамрагдсан тохиолдолд 4-өөс доошгүй жил
- 6-12 сарын сургалтанд хамрагдсан тохиолдолд 5-аас доошгүй жил

6.2.10. Хүндэтгэх шалтгаангүйгээр сургалтыг орхих, хангалтгүй суралцах, ёс зүйн болон бусад зөрчил гаргасан тохиолдолд сургалттай холбоотой гарсан зардлыг эгүүлэн төлж, улсыг хохиролгүй болгох.

#### **Долоо. Журмыг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага.**

7.1. Хэрэв суралцагч нь энэхүү журмын 6.2.9-д заасныг зөрчсөн тохиолдолд тухайн сургалттай холбоотой гарсан нийт зардлыг дараах хувиар эгүүлэн төлнө. Үүнд:

Сургалтаа дүүргэсний дараа ажилласан хугацаа	< 1 хүртэлх жил	1-2 хүртэлх жил	2-3 хүртэлх жил	3-4 хүртэлх жил	4-5 хүртэлх жил
Сургалтын хугацаа					
1-3 хүртэлх сар	90%	70%	50%	×	×
3-6 хүртэлх сар	90%	80%	60%	50%	×
6-12 сар	90%	80%	70%	60%	50%

7.2. Суралцагч нь хүндэтгэх шалтгаангүйгээр сургалтыг орхих, хангалтгүй суралцах, ёс зүйн болон бусад зөрчил гаргасан тохиолдолд сургалттай холбоотой гарсан зардлыг бүрэн эгүүлэн төлүүлнэ.

7.3. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн эмнэлгийн мэргэжилтэн, түүнийг нэр дэвшүүлсэн эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтныг энэ журамд заасан сургалтанд 2 жилийн хугацаанд хамруулахгүй.

7.4. Журмын бусад заалтыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.5. Талуудын 1.6-д заасан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг зөрчигдсэн тохиолдолд гэрээнд заасны дагуу эсвэл холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

#### **Найм. Гадаад сургалтын үр дүнг тооцох, хяналт тавих.**

8.1. ЭМХТ нь жил бүрийн I улиралд багтаан өмнөх жилийн гадаад сургалтын зохион байгуулалт, санхүүжилт, үр дүнтэй холбоотой дэлгэрэнгүй тайланг ЭМЯ-ны холбогдох нэгжид хүргүүлж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

8.2. ЭМХТ нь гадаад сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт, ажлын үр дүнгийн талаар эрүүл мэндийн байгууллагуудаас жил бүр мэдээлэл авч, тогтмол хяналт тавьж ажиллана.

8.3. ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь энэхүү журмын хэрэгжилт, түүний үр дүн, санхүүжилтэд төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийнэ.

